



**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/166

Есөнбулаг сум

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.4, 50.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар баталсан "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" 64, 2026 оны "Аймгийн 2026 оны төсөвт зохицуулалт хийх тухай" 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх чөлөөт бүс, үйлдвэр технологийн парк, эдийн засгийн чөлөөт бүсийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

	Үнэлгээний хорооны дарга: Н.Эрдэнэ-Очир (Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүд	3.Жаргалтуяа (Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
	4.Ууганбаяр (Хөндлөнгийн төлөөлөл ) (тохиролцсон)
	Ж.Мөнхцэцэг (Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл) (тохиролцсон)
Нарийн бичиг	4.Мэндбаяр (Худалдан авах ажиллагааны газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Н.Эрдэнэ-Очир)-нд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/13 дугаар "Үнэлгээний хороо байгуулах тухай" захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:zahiramjZax ZD 2026

8000010138